Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,162,856.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 17,728.1 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	223,581.8	139,892.1	(83,689.6)
Мөнгөн хөрөнгө	-	81,368.3	81,368.3
Авлага	180,195.2	-	(180,195.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,386.6	58,523.9	15,137.3
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	921,546.3	1,022,964.0	101,417.7
Үндсэн хөрөнгө	1,092,704.5	1,215,438.6	122,734.1
Хуримтлагдсан элэгдэл	(171,158.2)	(192,474.6)	(21,316.4)
<b>Нийт хөрөнгө</b>	1,145,128.1	1,162,856.1	17,728.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,145,128.1	1,162,856.1	17,728.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,145,128.1	1,162,856.1	17,728.1

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 81,368.3 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын санхүү даатгалын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны өөрчлөлт нь оны өмнөх оны ЭМД-ын сангаас авах өмнөх оны авлагын үлдэгдэл 180,195.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58,523.9 мянган төгрөг болж 15,137.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 204,068.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн ЭМГ-аар дамжуулан ЭМЯ бусад

байгууллагаас 30,481.6 мянган төгрөгийн бараа, материалыг шилжүүлэн авч, 216,496.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 2,916,2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,215,438.6 мянган төгрөг болж 122,734.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 54,965.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ЭМГ-аас 5,085.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, Коиса Олон улсын байгууллагаас 88,870.1 мянган төгрөгөөр ариун цэврийн байгууламжийн ажил хийгдсэн байна. Мөн тайлант онд Аймгийн ИТХ-ын 2022.09.16-ны өдрийн хуралдааны 10/46 дугаар тогтоолоор 26,186.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,162,856.1 мянган төгрөг болж 17,728.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд ЭМД-ийн сангаас санхүүжих нэг иргэнээр тооцсон зардлыг 661,525.8 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 223,529.2 мянган төгрөгөөр бууруулан 437,996.6 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой 8 удаа төсөвт өөрчлөлт оруулжээ

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-ийн сангаас 562,845.6 мянган, орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардлын санхүүжилтэд 39,066.0 мянган, нийт зарлага санхүүжилтийг 601,911.6 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 582,173.4 мянган, туслах үйл ажиллагааны орлогоор / нэмэлт/ 3,531.1 мянган, орон нутгийн төсвөөс 39,066.0 мянган, нийт 624,770,5 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 541,751.6 мянган төгрөг буюу 90.0 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 1,650.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, ЭМД-ийн сангаас авах санхүүжилтийг 19,327.8

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

мянган төгрөгөөр илүү авсан, туслах үйл ажиллагааны орлогоор 3,531.1 мянган төгрөгийг тус тус авч, олгосон санхүүжилтээс 81,368.2 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	601,911.6	541,751.6	60,160.0	90.0
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	39,066.0	37,415.4	1,650.6	95.8
АРГА ХЭМЖЭЭ 80302-Нэг иргэнд ногдох нормативт зардал	248,127.6	279,629.6	31,502.0	112.5
АРГА ХЭМЖЭЭ 81603- Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	284,943.0	276,299.9	8,643.1	96.8
АРГА ХЭМЖЭЭ 83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан нэмэлт санхүүжилт	29,775.0	29,775.0	0,00	100,0

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар 183,243.1 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэний 179,290.0 мянган төгрөг нь өмнөх оны ЭМД-гийн сангаас авах авлагын гүйлгээ, 4,953.1 мянган төгрөг нь хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн мөнгө байна. Нэмэлт санхүүжилтийн орлого зарлагын гүйлгээг санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд бүрэн тайлагнасан.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн

аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 94 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад 2022 оны 9-р сарын өөрчлөлтөөр батлагдсан төсөвт зардлын 560,761.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,411н4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 6,308.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 601,911.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас батлагдсан төсвөөс 60,160.0 мянган төгрөгийг хэмнэсэн ба хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зардлыг хэмнэсэн байна. Үүнээс :

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,650.6 мянган төгрөг
- Бараа , үйлчилгээний бусад зардлаас 9,509.4 мянган төгрөг
- Бичиг хэргийн зардлаас 581.4 мянган төгрөг
- Шуудан холбооны зардлаас 751.8 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тайлант онд тендер зарлаагүй ба дулаанаар хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун , хүнсний материал худалдан авах 4 гэрээний 169,968.5 мянган, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 754,091.4

мянган төгрөгийн 22 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 178,786.3 мянган төгрөгийн 18 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 210,872.7 мянган төгрөгийн 10 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба завсрын аудитаар цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022 оны 4-р сард 1 ажилтанд 105.0 мянган төгрөг, 5-р сард 1 ажилтанд 373.9 төгрөг, нийт 478.9 мянган төгрөгийг ТАЦ-ын программын ашиглалттай холбоотой тооцоолсон цалин болон гарт олгох цалин дээр нэмэгдэж илүү олгогдсон зөрчил илэрснийг төлбөрийн акт тогтоон 12-р сарын цалингаас суутган тооцуулсан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 785,5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг 2022.05.27-ны өдрийн 26 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Fas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	785.5	1	785.5	100,0
Зөвлөмж	1	48,613.7	1	48,613.7	100,0
Нийт дүн	2	49,399.2	2	49,399.2	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн үлдэгдэл жил бүр нэмэгдэж байгаа тул төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй нийлүүлэгдэж байгаа эмийн хугацаа, ашиглалт дээр анхаарч дүн шинжилгээ хийж төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах, төсвийн хөрөнгөөр авч буй үндсэн хөрөнгийн худалдан авах ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, түүний чанар, ашиглалтын байдалд Эрүүл мэндийн салбарын хэмжээгээр давтан аудит хийхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,773.0 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022 оны 3-р сард улаан бүсэд ажилласан ажилтнуудын илүү цагийн хөлсийг бодож олгохдоо 5 ажилтны ажилласан илүү цагийг 1,2-р сарын илүү цагтай давхардуулан бодож 1094.0 мянган төгрөгийг илүү олгосон

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон цалинг холбогдох ажилтнуудаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов

2. Цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022 оны 4-р сард 1 ажилтанд 105.0 мянган , 5-р сард 1 ажилтанд 374.0 мянган төгрөг, нийт 479.0 төгрөгийг ТАЦ-ын программын ашиглалттай холбоотой тооцоолсон цалин болон гарт олгох цалин дээр нэмж илүү олгоод 2022 оны 3-р улирлын санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:**Ажилтнуудад илүү олгосон цалин 479.0 мянган төгрөгийг холбогдох ажилтнуудаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Төсвийн гүйцэтгэлийг анхан шатны баримтаас шалгах явцад ЭМТ-ийн даргын 2022 оны 1-р сард албан томилолтоор ажилласан хоногоос 6 хоног нь улаан бүсэд ажилласан хугацааны илүү цагийн хөлс бодогдсон хоногтой давхцуулж 200,0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон цалинг холбогдох ажилтнаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022 оны 3-р сард улаан бүсэд ажилласан ажилтнуудын илүү цагийн хөлсийг бодож олгохдоо 5	1	1094.0	1	1094.0								

**Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

ажилтны ажилласан илүү цагийг 1,2-р сарын илүү цагтай давхардуулан бодож 1094.0 мянган төгрөгийг илүү олгосон												
Цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022 оны 4-р сард 1 ажилтанд 105.0 мянган , 5-р сард 1 ажилтанд 373.9 мянган төгрөг, нийт 478.9 төгрөгийг ТАЦ-ын программын ашиглалттай холбоотой тооцоолсон цалин болон гарт олгох цалин дээр нэмж илүү олгоод 2022 оны 3-р улирлын санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй	1	479.0	1	479.0								
Төсвийн гүйцэтгэлийг анхан шатны баримтаас шалгах явцад ЗМТ-ийн даргын 2022 оны 1-р сард албан томилолтоор ажилласан хоногоос 6 хоног нь улаан бүсэд ажилласан хугацааны илүү цагийн хөлс бодогдсон хоногтой давхцуулж 200,0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	200.0	1	200.0								
<b>дүн</b>	<b>3</b>	<b>1,773.0</b>	<b>3</b>	<b>1,773.0</b>								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар

26/14425182

БНА-2023/73/НА-СТА-ТУЛЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022 оны 3-р сард улаан бүсэд ажилласан ажилтнуудын илүү цагийн хөлсийг бодож олгохдоо 5 ажилтны ажилласан илүү цагийг 1,2-р сарын илүү цагтай давхардуулан бодож 1,094,052 төгрөгийг илүү олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг зөрчсөн.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажиллагсадад илүү олгосон цалин 1,094,052 /Нэг сая ерэн дөрвөн мянган тавин хоёр/ төгрөгийг ЭМТ-ийн дарга О.Гэрэлчимэг, нягтлан бодогч Ж.Дааханжав нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх<sup>1</sup>

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн дарга О.Гэрэлчимэг, нягтлан бодогч Ж.Дааханжав нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР  Д.ЦЭЦЭГМАА

6417143544  
БНА0067 9007423

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050076

26/АО14425182 ТООТ  
актын хавсралт

2023.01.22

Нэрс	1 дүгээр сард цалин бодогдсон хугацаа		2 дугаар сард цалин бодогдсон хугацаа			3 дугаар сард цалин бодогдсон хугацаа					Цалин бодогдсон хоног	Давхцан хоног	1 хоногийн цалин	Илүү тооцсон	
	1 дүгээр сард ажилласан хугацаа	Цалин бодогдсон хоног	1 дүгээр сард ажилласан хугацаа	Цалин бодогдсон хоног	2 дугаар сард ажилласан хугацаа	Цалин бодогдсон хоног	1 дүгээр сард ажилласан хугацаа	Цалин бодогдсон хоног	2 дугаар сард ажилласан хугацаа	Цалин бодогдсон хоног					3 дугаар сард ажилласан хугацаа
1 О.Гэрэлчимэг	01.19-01.26	7			02.13-02.23	10	01.01-01.10	10	02.21-02.28	8	03.01-03.03	2	3	48560	145680
2 Б.Амаржаргал	01.19-01.26	7			02.13-02.23	10	01.20-02.01	10			03.01-03.23	10	7	38422	268954
3 Д.Амгалан			01.26-02.02	7	02.18 - 02.28	10	01.20-02.01	10			03.13-03.23	10	7	28688	200816
4 С.Энхзаяа					02.03 - 02.13	10			02.11-02.21	10			3	43368	130104
5 Г.Мөнхчимэг					02.03 - 02.14	10			02.01-02.11, 02.21-02.28	18	03.01.03.03	2	9	38722	348498
ДҮН															<b>1094052</b>

ТОМИЛОЛТ

Гэрэлчимэг

2022.01.06

6х

300000

давхцсан

4х

200000



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 27/14425182  
БНА-2023/73/НА-СТА-743

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгах явцад 2022 оны 4-р сард 1 ажилтанд 105,000 төгрөг, 5-р сард 1 ажилтанд 373,960 төгрөг, нийт 478,960 төгрөгийг цалингийн программын ашиглалттай холбоотой тооцоолсон цалин болон гарт олгох цалин дээр нэмж илүү олгоод 2022 оны 3-р улирлын санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон цалин 478,960 /Дөрвөн зуун далан найман мянган есөн зуун жаран/ төгрөгийг холбогдох ажилтнуудаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх<sup>1</sup>

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Заг сумын ЭМТ-ийн дарга О.Гэрэлчимэг, нягтлан бодогч Ж.Дааханжав нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Б.МӨНХБАТ  
Д.ЦЭЦЭГМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050081



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар

28/944251/82

БНА-2023/73/НА-СТА-ТМЗ

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийг анхан шатны баримтаас шалгах явцад ЭМТ-ийн даргын 2022 оны 1-р сард албан томилолтоор ажилласан хоногоос 6 хоног нь улаан бүсэд ажилласан хугацааны илүү цагийн хөлс бодогдсон хоногтой давхцуулж 200,000 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5.бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Давхардуулан олгосон томилолтын 200,00 /Хоёр зуун мянган/ төгрөгийг О.Гэрэлчимэгээр төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх<sup>1</sup>

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн дарга О.Гэрэлчимэг, нягтлан бодогч Ж.Дааханжав нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050084